

Тахийн Мэдээ

№ 23/ 2025 оны 5 дугаар сар



ITG INTERNATIONAL TAKHI-GROUP

Алсын хараа:

Их говийг дархлан хамгаалсан 50 жил

Монголын тал нутагт 64,000 км² талбайтай цөлөрхөг болон цөл газрыг дархлан хамгаалсаар 50 жил өнгөрчээ. Энэхүү ухаалаг шийдвэрээр эрс тэс нөхцөлд гайхалтай дасан зохицсон ургамал, амьтан биологийн олон янз байдал бүхий байгалийн үнэт өвийг хамгаалж ирсэн юм. Их говь бол дэлхийн хамгийн том хуурай газрын хамгаалалттай бүс нутгийн нэг билээ.

Зургийг ©Петра Каченски

Зэрлэг адууны өвөг, түүний амьдрах орчныг хамгаалцгаая.

Гайхамшигт байгаль...

Говийн их дархан цаазат, шим мандлын нөөц газар нь Швейцар улсын газар нутгаас 1.5 дахин том. Хятад улстай хил залгаа өмнө зүгт орших энэхүү хамгаалалттай бүс нь Говийн их дархан цаазат газрын Б хэсэг (Зүүнгарын говь, 18,000 км²) болон зүүн талаар байрлах цөлөрхөг, Говийн их дархан цаазат газрын А (Алтайн өвөр, 46,000 км²) гэсэн хоёр хэсгээс бүрддэг. Энэхүү нөөц газрын дэлхий дахинд онцгойд тооцогдох шалтгаан нь асар том хэмжээ, алслагдмал байдлаас үүдэлтэй онгон зэрлэг байгалийн үзэсгэлэн төдийгүй, ландшафтын гайхамшигт олон янз байдал юм. Энд цөлөөс эхлээд цөлөрхөг, цөл-хээр, элсэн манхан, давст нуур, давст намаг, улирлын чанартай гол горхи, 50 гаруй баянбүрд, уулын хээр болон цөлжүү уулс хүртэл оршдог.

Эдгээр экосистем маш хуурай, халуун зун, хүйтэн өвлийн эрс тэс нөхцөлд дасан зохицсон олон ховор амьд биетийн амьдрах орон зай болдог.

Зөвхөн ГИДЦГ Б хэсэгт:

- 135 төрөлд хамаарах 204 зүйлийн ургамал,
- 49 зүйлийн хөхтөн,
- 15 зүйлийн хэвлээр явагч болон хоёр нутагтан,
- 150 гаруй зүйлийн шувуу бүртгэгдээд байна.

Өргөн уудам энэ нутагт хавтгай, хулан, хар сүүлт зээр зэрэг том хөхтөн амьтад чөлөөтэй нүүдэллэх боломжтой байдаг нь тэдгээрийн амьд үлдэхэд амин чухал нөхцөл юм.



Зэрлэг адууны хүндэт анд найзуудаа

Тун ухаалаг шийдвэр! Монгол, Зөвлөлтийн биологичдын зөвлөснөөр, Монгол Улсын Ардын Их Хурал 1975 онд Их говийг Дархан цаазат газар болгон хамгаалахаар шийдвэрлэсэн. Энэ бол тухайн үед Зөвлөлт Холбоот Улсаас ихээхэн хамааралтай, ердөө 1.5 сая хүн амтай, том газар нутагтай орны хувьд огтхон ч энгийн зүйл байгаагүй. Тэр алсын хараатай шийдвэрийн үр дүнд дэлхийн хамгийн сүрлэг цөлийн ландшафтуудын нэг эдүгээ унаган төрхөө хадгалан үлдэж чаджээ. Тухайн үед Их говийн баруун бүс, Б хэсэгт сүүлчийн зэрлэг тахь устаж үгүй болоод 10 гаруй жил болж байлаа. Зүүн бүс буюу А хэсэгт мазаалай болон хавтгайн үр удам өдийг хүртэл тэсч үлджээ. Тахь, та бидний дэмжлэгтэйгээр бүх бэрхшээлийг даван туулсаар сүүлчийн оромж нутагтаа дахин оршихын төлөө тэмцэж

байна. Харин тэмээ, баавгайн хувьд тэд устах аюулд орсон амьтдын жагсаалтад байсаар байна. Харамсалтай нь, ГИДЦГ-ын А хэсгийг дайран гарах уул уурхайн авто замын төлөвлөгөө тэдний хувьд сүйрлийн аюултай. Энэ бүхнээс үүдэн сүр жавхлантай Их говийг хамгаалахын тулд – ОУТГ бусад байгууллагуудтай хамтран энэ онгон дагшин нутгийг ЮНЕСКО-гийн Дэлхийн өвийн жагсаалтад бүртгүүлэхийг зорьж байна. Энэ бол бидний хийж буй ажлын нэг хэсэг бөгөөд таны хандив, дэмжлэгээр биелэлээ олж байгаа билээ. Та ч бас Монгол Улсын Ардын Их Хуралтай адил алсын хараатай байж, бууж өгөлгүй тэмцсээр байх биз ээ?

Доктор Райнхард Шнидриг, ОУТГ-ийн Ерөнхийлөгч

“Тахийн нөхөд”-ийн гишүүн болоорой!


2

Хувь хүний гишүүнчлэлийн жилийн хураамж 130,000 төгрөг
Оюутан, залууст зориулсан “Унага” гишүүний хураамж 50,000 төгрөг

...гайхалтай амьтад

Зургийг: ©Ребекка Блүмер

Тахийн унага үрчилж аваарай 300,000 төгрөг
<https://savethewildhorse.org/spenden/>



Зургийг: ©Кирил Руосо

Уудам орон зай, онгон зэрлэг байгаль, амьдрах орчин ба төрөл зүйлийн олон янз байдлаараа Их говийн шим мандлын нөөц газар дэлхийд хосгүй.

Их говийн биологийн олон янз байдал

Нэн ховор

Тоорой (*Populus diversifolia*)
Муркрофтийн жигд (*Eleagnus moorcrofti*)
Монгол буурцгана (*Chesneya mongolica*)
Цөлийн аргамжин цэцэг (*Cistanche deserticola*)
Ноосон шилбэт баглуур (*Anabasis eriopoda*)
Жанз шарилж (*Artemisia tomentella*)
Грубовын хөөндий (*Spongiocarpella grubovii*)

Хавтгай (*Camelus ferus*)
Мазаалай (*Ursus arctos gobiensis*)

Устаж болзошгүй

Монгол Бүйлс (*Amygdalus mongolica*)
Екатерины банздоо (*Saussurea catharinae*)
Зөөлөвтөр лавай (*Asterotamnus molluscus*)

Тахь (*Equus ferus przewalskii*)
Цоохор ирвэс (*Panthera uncia*)
Соргог бөхөн (*Saiga mongolica / tatarica*)
Хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*)
Хулан (Khulan, *Equus hemionus*)
Аргаль (*Ovis ammon*)
Сибирийн янгир (*Capra sibirica*)
Зүүнгарын даахай (*Stylodipus sungorus*)

Тусгайлан хамгаалах шаардлагатай унаган ургамал

Шар хотир (*Zygophyllum xanthoxylon*)
Зүүнгарын бутаргана (*Reaumuria soongorica*)
Пржевальскийн зээргэнэ (*Ephedra przewalskii*)
Ахар навчит баглуур (*Anabasis brevifolia*)
(Нийт 20 унаган ургамал)



Бусад энгийн төрөл зүйлс

Намхан гишүүнэ (*Rheum nanum*)

Потаниний улаан тулам (*Incarvillea potaninii*)

Зүүнгарын гоёо (*Cynomorium songaricum*)

Марцны аргамжин цэцэг (*Cistanche salsa*)

Заг (*Haloxylon ammodendron*)

Явган хайлаас (*Ulmus pumila*)



Зургийг: ©Кирил Руосо

Их говийн 64,000 км² газар нутаг бол нүүдэллэн амьдардаг том туурайтан амьтдын амьдрах орон зай билээ.

Эрсдэлд орсон эрдэнэ

Монгол Улс бол хүрээлэн буй орчныг хамгаалахад дэлхийд тэргүүлэгч орнуудын нэг билээ. Тусгай хамгаалалтад авсан нийт 300,000 км² талбай бүхий 120 гаруй газар нь тус улсын нийт нутгийн 20 орчим хувийг хамарна. Гэвч Их говийн эмзэг экосистемд аюул заналхийлсээр байна.

Цөлжилт

Цөлжилт голчлон бэлчээрийн даац хэтэрсэн мал аж ахуйгаас үүдэлтэй. Мал хэт олноор бэлчсэнээр хөрсийг чийгшүүлж, тогтоон барих чухал үүрэгтэй ургамлын бүрхэвчийг үгүй хийдэг. Үүний улмаас хөрсний элэгдэл нэмэгдэж, газрын доорх ус ширгэх, хөрсний давсжилт үүсэх зэрэг сөрөг үр дагаврууд бий болдог. Сүүлийн 30 жилд Монгол Улсын малын тоо гурав дахин өсч, 70 саяд хүрсэн бөгөөд дийлэнх нь ноолуурын чиглэлийн ямаа юм. Энэ өсөлт бэлчээрийн нөхөн сэргэх чадварыг алдагдуулж, тал нутгийн зэрлэг амьтдын амьдрах орчноор тогтохгүй монгол нүүдэлчдийн соёлын үндэс язгуурт аюул учруулж байна.

Уур амьсгалын өөрчлөлт

Ган гачгийн хор нөлөө даамжирч, гэмтэж доройтсон ургамлын нөмрөгт улам ихээр сөрөг нөлөө үзүүлж байна.

Эрдэс баялгийн олборлолт

Монгол Улс чулуун нүүрс, алт, зэс болон ховор элементүүдээр баялаг. Улсын тусгай хамгаалалттай газруудаас бусад бараг бүх нутаг дэвсгэрт уул уурхайн хайгуул хийгдэж, лиценз олгосон байдаг. Ил уурхайн аргаар олборлосон хүдрийг байнгын эрэлттэй Хятадын экспортын эдийн засагт зориулан ачааны машины цуваа тасралтгүй зөөдөг. Уурхайн замыг чухам ГИДЦГ-ын А хэсгийг дайруулан тавихаар төлөвлөж байгаа нь байгаль, ургамал, амьтанд ямар хор хөнөөл учруулахыг тааварлахад бэрх. 2025 оны нэгдүгээр сард гаргасан Их говийг “Монголын Говь” нэрээр ЮНЕСКО-гийн Дэлхийн өвд бүртгүүлэх санал энэ төлөвлөгөөтэй зөрчилдөж болзошгүй.

Хулгайн ан

Хэдийгээр бусад эрсдэлтэй харьцуулахад хулгайн ан бага хэмжээгээр нөлөөлдөг ч тоохгүй орхиж болохгүй. Хулгайн ан, цөлийн хатуу ширүүн орчинд амьд үлдэхийн төлөө тэмцэж буй амьтдын амьдрах орчныг алдагдуулж, хор хөнөөл учруулна.



Зургийг: ©Ребекка Блүмер

Монголын нүүдэлчин соёлыг хамгаалах нь

Зургийг: ©Кирил Руосо



Их говийн шим мандлын нөөц газар болон орчны бүс нь Монголын олон мянган жилийн түүхтэй нүүдэлчин соёлын үндэс суурь төдийгүй нийт олноор тал нутгийн уламжлал, заншлаа өнөөг хүртэл хадгалан аж төрж буй соёлын үнэт өв юм.

Эрэлт хэрэгцээгээ бие даан хангаж ирсэн энэхүү эдийн засгийн эргэлтэт тогтолцоог мөнгөний эдийн засгийн нөхцөлд тогтвортой авч үлдэх тулгамдсан асуудал нь орчин үед сорилт болж байна. Үүнийг шийдвэрлэх нь нүүдэлчин соёлын тэсч үлдэх цорын ганц зам билээ.

Манай нийгэм-эдийн засгийн төсөл, малын тоо толгойг нэмэгдүүлэлгүй, цөөн тооны малаас илүү өндөр нэмүү өртөг бий болгох боломжийг малчдын хоршоодод олгож байна.

Жамаараа үргэлжлэх говийн амьдрал

Бид нэн түрүүнд хамгаалах шаардлагатай төрөл зүйл амьтдын төлөө ажилладаг. Үүний тулд олон талт үйл ажиллагаа явуулах шаардлага гардаг ба эдгээрийг одоогоор агроэкологич Лена Михлерийн удирдлага дор Олон Улсын Тахь Групп (ОУТГ) хэрэгжүүлж байна:

ГИДЦГ-ын Б нөөц газарт тахь адууны амьдрах чадвартай популяц бүрдүүлэх

Энэ жил цаг тухайд нь нэмэлт тэжээл өгсний ачаар тахь өвлийг өнтэй давсан ч хавар зүтгүүхэн үргэлжилж, 3-р сар гартал өвс тавьж өгөх хэрэгтэй болсон. 2024 онд хандивын хөрөнгөөр худалдаж авсан ачааны машин энэ ажилд маш их үүрэг гүйцэтгэсэн билээ. Одоогийн байдлаар 70 орчим гүү хээлтэй байгаа тул байгалийн нөөц газар дахь тахийн тоо толгой цаашид өсөх боломжтой харагдаж байна. Энэ жилийн анхны унага 2025 оны 4 дүгээр сарын 13-нд төрсөн.

Гэвч тахийн популяц эмзэг хэвээр бөгөөд хэд хэдэн томоохон эрсдэлд өртөж байна. Үүнд: хэт олон бог малаас үүдэлтэй бэлчээрийн өрсөлдөөн, халдварт өвчин дамжих эрсдэл, эрс тэс цаг агаар (ялангуяа ган гачиг, хүйтэн өвөл), мөн генетикийн хязгаарлагдмал нөөцөөс шалтгаалсан ойр төрлийн цус ойртолт, хариулгагүй бэлчих гэрийн адуутай эрлийзжих зэрэг аюулууд орно.

Тусгай хамгаалалттай газарт хэрэгжүүлж буй гол ажлуудын нэг бол тахь болон бусад зэрлэг амьтдын мониторинг бөгөөд үүнийг байгаль хамгаалагчид гүйцэтгэдэг. Одоо тэд бүртгэл хяналтанд SMART платформ ашиглан улам бүр үр дүнтэй ажиллаж байна. Энэхүү програм хангамж бүхий судалгааны хэрэгсэл нь мэдээлэл цуглуулах, боловсруулах, тайлагнах, мөн дэлгэрэнгүй тэмдэглэлээс чухал өгөгдлийг хялбар гаргаж авах үйл явцыг стандартчилж, энгийн болгодог. SMART нь амьтдыг хамгаалах арга хэмжээ, зөрчлийг илрүүлэх шийтгэх, аялал жуулчлалын менежмент, байгалийн нөөцийн ашиглалт, боловсрол, гүйцэтгэл ба эрсдлийн түвшинг үнэлэх зэрэг олон чиглэлээр өгөгдөл цуглуулж чадна.

Мөн байгаль хамгаалагчдыг SMART систем ашиглах талаар сургалтанд хамруулах нь чухал ажлуудын нэг юм.



2019 онд талбайг хоёр дахин өргөтгөсөн ГИДЦГ-ын Б хэсгийн орчны бүсийг тодорхойлж, ашиглалтын нөхцөлийг тогтоох

Хоёр аймгийн таван сумын оролцогч талууд болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж, 2024 онд уг томоохон ажлыг гүйцэтгэсэн.

*Мануулын зулзага - Ногоолой
Зургийг ©Отгонбаяр Баатаргал*

- онгон байгалийн өвийг хамгаалах бидний амлалт



Гурван булгийг сэргээх, хамгаалах

Бидний хийсэн хашлага хамгаалалт, амьтад олноор ундаалдаг усны эх үүсвэрийг гишгэгдэж, шавраар дүүрэхээс сэргийлдэг. Үүний дүнд цөлийн олон амьтдад амин чухал энэ усны нөөц ундны чанараа хадгалж байна.

Онгон байгалийн өвийг хамгаалах бидний амлалт (үргэлжлэл)

Хамгаалалтын захиргааны шинэ төв “Говийн өргөө” цогцолбор

Захиргааны хэсэг, үзэсгэлэн, мэдээллийн танхим, байрлах байр болон сургалт семинарын хэсэг бүхий шинэ цогцолборын барилгын зураг төслийг 2021 онд хийсэн ба одоогийн байдлаар, 2025 оны намар эхлэхээр төлөвлөж байна.

Манай нийгэм-эдийн засгийн төсөл бэлчээрийн даац хэтрэлтийг бууруулж, сэргийлнэ

Ноолуур болон тэмээний ноосыг малчдын хоршоонд боловсруулснаар илүү өндөр нэмүү өртөг бий болж, улмаар малчдын орлогыг бууруулахгүйгээр ямааны тоо толгойг цөөлөх боломж бүрддэг. Эхний удаад Герман-Монголын загвар зохион бүтээгчидтэй хамтран тэмээний ноосон бүтээгдэхүүн үйлдвэрлэж, борлуулсан. Хоршооны ноолуур, тэмээний ноос, тэдгээрээр хийсэн бүтээгдэхүүний эрэлт Монголд төдийгүй Швейцар, Герман улсад өндөр байна.

10 орны Тахь хамгаалах хөтөлбөрүүдийн хамтын ажиллагаа

2024 оны 9 дүгээр сарын сүүлчээр Монголын Хустайн байгалийн цогцолбор газарт зохион байгуулсан семинарын үеэр тохиролцсон олон улсын тахь хамгаалагч мэргэжилтнүүдийн хамтын ажиллагаа, харилцаа холбоо, өгөгдөл харилцан дамжуулалтыг сайжруулах ажил тогтвортой хэрэгжиж эхэллээ.

Хар сүүлт зээрийн экологийн талаархи таван жилийн судалгааны төсөл

2024 оны 9 дүгээр сард эхэлсэн уг судалгаа нь энэхүү бага судлагдсан, өвөрмөц амьтны амьдрах орчны ашиглалт болон шилжилт, нүүдлийн хэв маягийг тодруулах зорилготой. Одоогоор 12 зээрэнд хиймэл дагуулын GPS хүзүүвч зүүсэн бөгөөд 2025 онд нэмж 10 зээрэнд зүүхээр төлөвлөсөн. Эхний үр дүнгээс харахад, хар сүүлт зээр нөөц газрын ихэнх хэсгээр нүүдэллэн, өргөн хүрээнд ашиглаж байна.

Их говийн шим мандлын нөөц газрыг ЮНЕСКО-гийн Дэлхийн өвд бүртгүүлэх өргөдөл гаргахад хамтран ажиллах

Майкл Зукковын сангийн зүгээс ОУТГ болон бусад түншүүдийн дэмжлэгтэйгээр боловсруулсан өргөдлийг 2025 оны 1 дүгээр сард албан ёсоор өргөн барьсан ба одоогоор шалгалтын үе шатандаа явж байна.



Зургийг: ©Далайцэрэн Сүхбаатар

Зүйлийн хөрөг: Говийн баавгай Мазаалай¹



Youtube-Clip <https://www.youtube.com/watch?v=AZla>

Өргөн уудам голарктик тархацтай хүрэн баавгай нь морфологи болон зан төлөвийн хувьд маш олон янз байдаг. Өмнөд Европынх ойролцоогоор 70 килограмм жинтэй, ихэвчлэн ургамал иддэг бол загасаар хооллодог Кодиак баавгай нь үүнээс арав буюу түүнээс дээш дахин их жинтэй байж болно. Дэлхий даяар ерөнхийдөө энэ төрөл зүйл мөхөх аюулд ороогүй ч мөхлийн эрсдэлтэй олон жижиг популяц байгаа юм. Генетикийн хувьд бүрэн тусгаарлагдсан, экологи талаасаа өвөрмөц нэгэн дэд төрөл бол Говийн баавгай буюу Мазаалай билээ. 20,000 км² орчим талбайд тархсан энэхүү ховордсон амьтны тоо толгой IUCN-ын мэдээгээр ердөө 20-40 (магадгүй 11-22) гэж тооцогддог. Мазаалай биеэр жижиг, 50-130 килограмм жинтэй, ГИДЦГ-ын А хэсэгт буюу цөлийн орчинд амьдардаг.

Аагим зуны халуунд ихэвчлэн ургамлын үндэс, жимс мэтээр хооллох ба нийт хоол тэжээлийнх нь дөнгөж 8%-ийг газарт үүрлэдэг жижиг амьтад бүрдүүлнэ. Өвлийн хүйтэнд баавгай өвлийн унталт буюу ичээнд ордог. Хуурай, халцгай газар нутгаараа тэд ихэвчлэн ганцаар хэрэн хэсч, булаг шанд, усны эх үүсвэрийн ойролцоо бүсэд байрлана.

Удаан хугацаанд хийгдсэн генетик судалгаанаас харахад Мазаалайн популяц нь генетикийн хувьд бүрэн тусгаарлагдсан ч харьцангуй тогтвортой байгаа юм. Гэвч хүйсийн харьцаа маш их алдагдсан, эр хүйс давамгайлсан нь тэсч үлдсэн жижиг популяцийн хувьд генетикийн сорилт болж байна. Мөн мазаалайн ДНХ-д илэрч байгаа цөөн тооны аллел ген (генийн хувилбар) популяцийг тогтвортой бус болгодог. Митохондрийн ДНХ-ийн судалгаагаар мазаалай нь өвөг гарлаар холбогддог Төвд, Гималайн "цэнхэр баавгай"-тай бус харин Пакистаны хүрэн баавгайтай хамгийн дөхүү байдаг.²

Говийн баавгайд тулгарч буй гол аюул нь цөөн тоо толгой, цөлийн нам дор газарт тусгаарлагдсан тааламжгүй нөхцөл, мал аж ахуй болон суурин газрууд, генетикийн хязгаарлагдмал янз байдал, популяцийн тохиромжгүй бүтэц, мөн маш хатуу ширүүн орчин юм. 1959 онд мазаалай агнахыг хориглож, 1985 оноос ГИДЦГ-ын А хэсгийн хамгаалалтын захиргаа хавар, намрын улиралд тодорхой байршлуудад улаан буудай, эрдэнэшиш, лууван, манжин тавьж эхэлсэн билээ.

¹"Ursus arctos". IUCN Red List of Threatened Species. doi:10.2305/iucn.uk.2017-1.rlts.t41688a114261661.en.

²Tumendemberel, O et al.. Molecular Ecology. 32 (18): 5156–5169. doi:10.1111/mec.17091

Хамтдаа зэрлэг адууны ирээдүйг хамгаалъя



“Нутгийн хүн амын аж байдлыг тогтвортой сайжруулснаар Их говийг хамгаалах ажил амжилтанд хүрнэ. Ноолуурын хоршоолол болон Говийн Өргөө цогцолбор нь энэхүү зорилгод чиглэсэн чухал алхам юм.”

Лена Михлер, Швейцар улс дахь ОУТГ-ын Удирдах захирал

Таны хандив үр дүнтэй – хувь нэмэр бүхэн үнэ цэнэтэй!

150,000 төгрөг-

Та ОУТГ-ын судлаач
Н.Анхзаяад зэрлэг амьтдын
судалгааны багаж хэрэгсэл
авахад тусална.

250,000 төгрөг-

Та байгаль хамгаалагчдын
хуваарьт эргүүлийн
зардлын тодорхой хэсгийг
санхүүжүүлнэ.

300,000 төгрөг-

Та булаг дээр байрлуулах нарны
цэнэг хураагуур бүхий зэрлэг
амьтдын хяналтын камер
авахад хувь нэмэр оруулна.

600,000 төгрөг-

Та хар сүүлт зээрийн нүүдлийг
хянах хиймэл дагуулын
холбооны зургаан сарын
зардлыг төлнө.



Тэхийн Мэдээний энэхүү
дугаарыг "1 wild" цагаас ивээн
тэтгэв.
www.1wild.org

ОУТГ-ын удирдах зөвлөл сайн дурын үндсэн дээр ажилладаг.

Таны хандив бүр зэрлэг тахь болон тэдний амьдрах орчныг хамгаалахад шууд зориулагдана.

Facebook Instagram-аар биднийг дагаарай



Хандивын данс

Олон Улсын Тахь Группын Монгол дахь төлөөлөгчийн газар
ХХБ 499114883 ам. долл.
499248691 төгрөг

Байгаль орчинд ээлтэй цаасан дээр хэвлэв. FSC
(Ойн Удирдах Зөвлөл) / EX Эко шошгоны цаас



Эрхлэн гаргасан
Freunde des Wildpferdes
c/o Stiftung Wildnispark Zürich
Alte Sihltalstrasse 38
CH-8135 Sihlwald / ZH
www.savethewildhorse.org
info@savethewildhorse.org
itg.ulaanbaatar@gmail.com